



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/654

Булган сум

**Нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авах
ажлын хэсэг томилох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаал, 2023 оны А/439 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх, нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:

Байгаль орчны газрын дарга

Гишүүд:

Байгаль орчны газрын байгаль орчны хяналтын Улсын

байцаагч

Байгаль орчны газрын усны асуудал хариуцсан

мэргэжилтэн

Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын

холбогдох мэргэжилтэн

Сав газрын захиргааны холбогдох мэргэжилтэн

Сумын байгаль орчны хяналтын Улсын байцаагч

Сумын Газрын даамал

Сумын иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Байгаль орчны газрын газар, газрын хэвлийн ашиглалт,

хамгаалалт хариуцсан мэргэжилтэн

2. Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх, нөхөн сэргээлтийг ажлыг холбогдох хууль, стандартын дагуу хүлээн авч, аймгийн Засаг даргын удирдлагын багийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн дарга (А.Гантөмөр)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны А/688 дугаар захирамж, 2023 оны А/755 дугаар захирамжийг тус тус хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Засахирамж

6324010907